131101	Төрийн болон орон нутгийн өмчит этгээдээс авсан хандив тусламж		270,000,000.00
1311	Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагаанаас ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах хөрөнгөнөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,683,849.00	180,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,010,951.00	324,431,425.08
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас орсон нэмэлт орлого	1,980,000.00	1,907,852.00
	Нэмэлт санхүүжилт дансны үлдэгдэл		10,180,616.08

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийслэлийн Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны бүртгэл, хөрөнгийн тооцоо бодолт, өглөг авлагын дансны баталгаажуулалт, батлагдсан төсвийн хүрээнд төсвийг зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ий ахлах аудитор Б.Мягмар аудитор С.Дашдондог, туслах аудитор Э.Болд нар гүйцэтгэж, хяналтыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ий захирал Ж.Цэцэгмаа, НТАГ-ын аудитын менежер С.Гантөгс, хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Релаэнс секюритиз аудит” ХХК-д 2021 оны 02 дүгээр сарын 24-ний өдрийн 86 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Хэвтүүлэн эмчлүүлэх, яаралтай тусламж эрчимт эмчилгээ зэрэг үйлчилгээг хоёрдогч шатанд Нийслэлийн Хан-Уул дүүргийн иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх НЭМГ-ын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр үр нөлөөгүй байна. Шалтгаан нь: Байгууллагын дотоод хяналтын ажилтан нь ажлын байрны тодорхойлолтоор эрх зүйч, эмч мэргэжилтэй хүн ажилладаг бөгөөд 2021 оны дотоод хяналтын ажилтны хийсэн ажлын тайлангаас үзэхэд эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, Эрүүл мэндийн сайдын тушаал, албан даалгаврын хэрэгжилтийг хянаж ажилласан байна. Дотоод хяналтын ажилтны албан үүргийн тодорхойлолтод санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт, чиг үүрэг тусгагдаагүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор дотоод аудиторын тайлант оны ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар: Харьяалах дээд байгууллагаас санхүүгийн чиглэлээр хяналт, шалгалт хийгдээгүй бөгөөд Нийслэлийн эрүүл мэндийн газрын болон ЭМЯ-ны дэмжлэгт Цар тахал Ковид-19-ын үеийн бэлэн

байдал авах арга хэмжээний тушаал шийдвэр, зааврын хэрэгжилтэд хяналт шалгалт, үнэлгээ хийгдсэн. ЭМДЕГ-ын газар дээрх шалгалтад 1 удаа хамрагдсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн 4,244,893.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 84,897.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 67,918.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Ковид-19 цар тахалтай холбоотой эмчилгээ, тусламж үйлчилгээний зардал нэмэгдсэн шалтгаанаас материаллаг байдлын түвшинг 2021 оны нийт зардлын дүн 7,150,007.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 143,000.1 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,079,552.7 мянган төгрөгөөр буюу 87.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		19,332.2	19,332.2
Авлага	1,203.2	2,363,858.6	2,362,655.4
Урьдчилгаа			
Бараа материал	386,931.6	984,248.7	597,317.1

Аудитын код ХАК-2022/804/НА-СА-ТШЗ

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Үндсэн хөрөнгө	6,569,106.2	9,669,354.2	3,100,248.0
Нийт хөрөнгө	6,957,241.0	13,036,793.7	6,079,552.7
Өр төлбөр		497,013.8	497,013.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,957,241.0	12,539,779.9	5,582,538.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,957,241.0	13,036,793.7	6,079,552.7

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 19,332.2 мянган төгрөг болж 19,332.2 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгийн санхүүжилтийн дансны үлдэгдэл 10,180.6 мянган төгрөг, Нийгмийн даатгалын сангаас орж ирсэн санхүүжилтээс 9,151.6 мянган төгрөгийн нийт 19,332.2 мянган төгрөг мөнгөн хөрөнгийн дансанд үлдсэнээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 2,363,858.6 мянган төгрөг болж 2,362,655.4 мянган төгрөгөөр өссөн нь ЭМДС-аас авах авлага 2,361,800.0 мянган төгрөг, тооллогоор илэрсэн дутагдал 200.0 мянган төгрөг, Нийгмийн даатгалаас авах авлага 700.0 мянган төгрөг зэргээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд он удаан жил болсон авлага байхгүй байна. Дээрх авлагууд тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 984,248.7 мянган төгрөг болж 597,317.1 мянган төгрөгөөр өссөн нь 2021 онд Цар тахал Ковид-19-өөс шалтгаалан 1,968,410.3 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгсэл төсвийн хөрөнгөөр, 1,134,829.4 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгслийг хандиваар орлого авч, 2,676,103.4 мянган төгрөг ба 81.3 хувь нь эм, эмийн боох материал, 452,635.6 мянган төгрөг ба 13.7 хувь нь хүнсний материал, 162,890.9 мянган төгрөг ба 5 хувь нь бичиг хэрэг, аж ахуйн материал, сэлбэг, шатахуун зэрэг бусад хангамжийн материал зарцуулжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд 2021 онд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй гэж тооллогын бүртгэл өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрээр гарсан байна.

Тус байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрээр 2021 оны жилийн эцсийн тооллогоор 104,134.8 мянган төгрөгийн хангамжийн материалыг акталж устгасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9,669,354.2 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 3,100,248.0 мянган төгрөгөөр буюу 47,2 хувиар өссөн байна. Үүнд:

2021 онд Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 13,974.2 мянган төгрөгийн, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 3,866,232.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө тус тус нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн элэгдэл 779,958.8 мянган төгрөгөөр байгуулсан, актлаж устгасан үндсэн хөрөнгө байхгүй, мөн шилжүүлсэн үндсэн хөрөнгийн гүйлгээ гараагүй байна.

Биет бус хөрөнгийн үлдэгдэл 2021 онд 890,422.8 мянган төгрөг өмнөх оноос 550.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь санхүүгийн программ хангамжийн эрх нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 497,013.8 мянган төгрөг болж, 497,013.8 мянган төгрөгөөр өссөн нь Энэ нь Ковид-19 цар тахлаас шалтгаалан эм, эмийн хэрэгслийн үнийг эм ханган нийлүүлэх байгууллагад өгөх өглөг бөгөөд НДС-аас санхүүжилт хугацаандаа орж ирээгүйгээс шалтгаалан эм, эмнэлгийн хэрэгслийн өглөг үүсчээ. Өглөгүүд тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.

Урт хугацаат өр төлбөр үүсээгүй байна

Нийслэлийн Хан-Уул дүүргийг нэгдсэн эмнэлэг"-ийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 15,691,796.2 мянган төгрөг болж өмнөх оноос 8 961,551.6 мянган төгрөгөөр буюу 233.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан шалтгаан нь: Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал 1,434,805.7 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө 3,866,232.6 мянган төгрөг, Нийгмийн даатгалын сангаас 9,294,489.2 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 443,487.4 мянган төгрөг, ЗГ-ын нөөц сангаас 180,000.0 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 50,646.2 мянган төгрөг, бусад газраас 270,000.0 мянган төгрөг, ЭМЯ-аас санхүүжилтээр 150,000.0 мянган төгрөг тус тус авснаас шалтгаан орлого нэмэгджээ.

Нийт зардал 10,109,257.3 мянган төгрөг байна. Зардал өмнөх оноос 5,323,181.0 мянган төгрөгөөр буюу 211.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан шалтгаан нь бараа ажил үйлчилгээний зардал 5,041,443.5 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнээс: цалин нэмэгдэл, урамшуулал 1400.290.3 мянган төгрөгөөр, НДШ 233,063.5 мянган төгрөгөөр, нормативт зардал 2,551,232.5 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 281,737.6 мянган төгрөгөөр, бусад зардал 575119.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Энэ нь цар тахал Ковид-19-тэй холбогдон эм, эмнэлэгийн хэрэгсэл, ажиллах хүчний цалин хөлс болон холбогдох урамшуулал, даатгалын зардлууд нэмэгдсэнээс шалтгаалан зардал өссөн байна. Дээрх зардлууд нэмэгдсэн бас нэг шалтгаан нь 2021 онд тус эмнэлэг нь 145 ортой түр эмнэлэгийн Хангарьд ордонд нээн ажиллуулсан байна.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэгийн 2021 оны санхүүгийн үр дүн 5,582,538.9 мянган төгрөг бөгөөд өмнөх оны үр дүнд өөрчлөлт ороогүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 8,383,497.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 8,383,497.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 8,383,497.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх НЭГ хөтөлбөрийн ХОЁР арга хэмжээг санхүүжүүлэхээр 8,383,497.0 мянган төгрөгийн төсөв баталснаас эрүүл мэндийн даатгалын сангаас 8,315,076.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 68,420.4 мянган төгрөгний тус тус эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр НДС-аас 6,932,672.9 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 76,486.2 мянган төгрөг, Бусад эх үүсвэрээс 150,000.0 мянган төгрөг нийт 7,159,159.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 7,150,007.5

мянган төгрөгийг зарцуулж 9,151.6 мянган төгрөгийг мөнгөн хөрөнгө дансанд үлдэгдлээр бүртгэсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,150,007.5 мянган төгрөг буюу 85,3 хувьтай байгаа нь цалин, бичиг хэрэг, сэлбэг зэрэг хангамж бараа материалын зардлыг 1,233,489.5 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой гэж үзлээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайланд хандив тусламжаар дээд шатны төсвийн захирагчаас 324,431.4 мянган төгрөг, ЗГНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 180,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 1,907.9 мянган төгрөг, бусад эх үүсвэрээс 270,000.0 мянган төгрөг нийт 776,339.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс ажиллагсдын нэмэгдэл урамшуулалт цалинд 450,000.0 мянган төгрөг, нэг удаагийн буцалтгүй тусламжинд 283,436.2 мянган төгрөгийг хангамжийн бараа материал, нормативт зардал зэрэг бусад зардалд 32,722.5 мянган төгрөгийг тус тус зарцуулж, үлдэгдэл 10,180.6 мянган төгрөгийг мөнгө дансанд үлдэгдлээр харуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого, зардал гаргаагүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг:

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус хэлтэс нь дээд шатны төсвийн захирагчаас 324,431.4 мянган төгрөгийн хөрөнгө хувиарлуулан авч энэхүү 324,431.4 мянган төгрөгийн санхүүжилтийг ажилтан албан хаагчдын цалин нэмэгдэл урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламжинд зарцуулсан ба уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Бусад асуудлын хэсэг:

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ХОЁР зорилтын хүрээнд ГУРВАН арга

Аудитын код ХАК-2022/804/НА-СА-ТШЗ

хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг нь 2021 онд нийт 3,126,045.7 мянган төгрөгийн 154 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 279,600.0 мянган төгрөгийн 42 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаардлага /зөрчил давтан гаргахгүй байх, хариуцлага тооцуулах/, зөвлөмж өгөх

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

3.10.1. Завсрын аудитын үр дүн:

Аудитын код ХАК-2022/804/НА-СА-ТШЗ

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг-ийн 2021 оны (эхний хагас жил, III улирлын) санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 27,600.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 27,600.0 мянган төгрөгийн алдааг залруулга хийлгэж, 8 зөрчилд зөвлөмж өгсөн.

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 27,600.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгуулж, 7 зөвлөмжийг хэрэгжүүлжээ. 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Зөвлөмжийн хэрэгжилт 80 хувь.

3.10.2. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4,595.0 мянган төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргуулахгүй байх 4 зөвлөмж өгч, зөвлөмжийг биелүүлсэн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт:

мянган төгрөг

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	4	4,595.0	4	4,595.0			
Нийт дүн	4	4,595.0	4	4,595.0			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нийслэлийн Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэгийн 2021 оны санхүүгийн тайлангаар гарсан 2,363,858.6 мянган төгрөгний авлага, 497,013.8 мянган төгрөгний өр төлбөрийн тооцооны хэрэгжилтийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 371,400.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын хугацаанд 307,200.0 мянган төгрөгний зөрчлийг арилгуулж, 25,600.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 20,600.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргуулахгүйн тулд 18,000.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа: Завсрын аудитаар илэрсэн 27,600.0 мянган төгрөгийн /хоолны орц нормативыг тооцохдоо тооцооллын алдаа гаргасан, эмийн зарцуулалтын тайланг нягтлан бодогч хянаагүй/ зөрчлийг арилгуулж, холбогдох анхан шатны баримтыг бүрдүүлж баталгаажуулав.

ЯМАР, ЯМАР ЗӨРЧИЛ?

4.2 Төлбөрийн акт

Тус эмнэлэгийн өглөг дансанд орсон 25,600.0 мянган төгрөгийн орлогыг Эрүүл Мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 3-ын 3-т заасан / мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, эмийн бодисыг ханган нийлүүлэхэд тусгай зөвшөөрөл бүхий байгууллага хангана/ гэсэн заалтыг зөрчсөн гэж үзээд тус эмнэлэгийн дотоод хяналтын ажилтан уг эмний үнийг холбогдох хүмүүсээр төлүүлж өглөг дансанд бүртгэж авсан боловч улсын төсөвт оруулаагүй тул төлбөрийн акт тогтоож байна.

4.3 Албан шаардлага

Хоол үйлдвэрлэлийн болон хүнсний материалын зарцуулалтын тайланг тогооч нараар гаргуулдаггүй, хүнсний няраваас шууд зардлын дансанд бичиж тайлагнадаг нь анхан шатны бүртгэлээр хүнсний материалд тавих хяналтыг алдагдуулж байна. Түүвэр шалгалтаар 2021 оны 7 сард Био комбинатын хүүхдийн эмнэлэг нь хүнсний материалын няраваас 20,600.0 мянган төгрөгний хүнсний материалыг хүлээж аваад ямар хоол хэдэн порц хийсэн тайлан байхгүй шууд зардалд бичсэн байна. Энэ нь НББ-ийн хуулийн 13 дүгээр зүйлийн 4-д /Аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтаар баталгаажуулна/ гэсэн заалтыг мөрдөж ажиллах

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Анхан шатны бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: 2021 онд түүвэр шалгалтаар тасаг нэгж бүрт эмийн тооцооны үлдэгдлийг хөтөлдөггүй, эм эмнэлэгийн хэрэгслэлийн зарцуулалтыг тасаг нэгжүүдэд тавьж олгохдоо холбогдох эмч, эрхлэгч нараар хянуулж гарын үсэг зурж баталгаажуулдаггүй, эмийн няраваас шууд зардалд бичдэг 18,000.0 мянган төгрөгний зөрчил илэрлээ

1.2 Зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 13 дүгээр зүйлийн 1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно/ гэж заасны дагуу холбогдох анхан шатны бүртгэлийг үнэн зөв хөтлөж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллага болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Хүнсний няравын агуулахын бүртгэл хөтлөөгүй, үлдэгдлийг тухай бүр нягтлан бодогч хянаж гарын үсэг зурж баталгаажуулаагүй	1		1							
2	45 ортой хүүхдийн эмнэлэгийн хоол болон эмийн зарцуулалтын тайлан хийгээгүй	1	20,000.0	1	20,000.0						
3	Хүнсний материалын тооцоог хийхдээ тооцооллын алдаа гаргасан	1	7,600.0	1	7,600.0						
4	Эмч ажиллагсдын хэргэлж байгаа эд хөрөнгийн картыг бүрэн хөтлөж хэвших	1		1							
5	Эд хөрөнгийн тооллого, тооцоо бодолт бүрэн хийгдээгүй	1		1							
7	Авто машины түлш шатахууны норм нормативыг баримтлан шатахууны тооцоог бодож хэвших	1		1							
8	Тасаг нэгж бүрт сар бүр эмийн тооцооны үлдэгдлийг бүртгэдэггүй, эм эмнэлэгийн хэрэгслэлийн зарцуулалтыг тасаг нэгжүүдэд тавьж олгохдоо холбогдох эмч, эрхлэгч нараар хянуулж гарын үсэг зуруулж баталгаажуулдаггүй эмийн няраваас шууд зардалд бичдэг зөрчил илэрсэн	1	18,000.0							1	18,000.0
9	2021 оны эхний хагас жилд Финанс баланс интернэйшнл ХХК-аас 25,6 сая төгрөгний мансууруулах, сэтгэцэнд нөлөөлөх эм худалдан авч эм, эмийн хэрэгслэлийн зарцуулалтанд тооцсон. Эрүүл Мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 3-ын 3-т заасан	1	25,600.0					1	25,600.0		

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	/мансууруулах, сэтгэгэнд нөлөөлөх эм эмийн бодисыг ханган нийлүүлэхэд тусгай зөвшөөрөл бүхий байгууллага хангана/ гэсэн заалтыг зөрчсөн байна. Энэхүү эмийн үнийг хуучин удирдлагаар нь буцаан төлүүлсэн боловч улсын төсөвт төвлөрүүлээгүй өглөг дансанд байсаар байгаа тул улсын төсвийн дансанд оруулахаар төлбөрийн акт тогтоов.										
10	Хоол үйлдвэрлэл болон хүнсний материалын зарцуулалтын тайланг тогооч нараар гаргуулж, нягтлан бодогч, хоол зүйч нар хяналт тавьж ажиллах	1	20,600.0					1	20,600.0		
Дүн		10	91,800.0	6	307,200.0	1	25,600.0	1	20,600.0	1	18,000.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн оруулаагүй	1	279,600.0	1	279,600.0					1	
Дүн											
Нийт дүн		11	371,400.0	6	307,200.0	1	25,600.0	1	20,600.0	3	18,000.0

Бэлтгэсэн:
“Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн

Захирал

Аудитор

Аудитор




Ж.Цэцэгмаа

Б.Мягмар

С.Дашдондог

ЭН КОД ХАК-2022/804/НА-СА-ТШЗ



23